



ГОВЬСҮМБЭР АЙМАГ  
БАЯНТАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ТАМГИН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2022 оны 04 сарын 21 өдөр

Дугаар 4/15

Баянтал сум

Ур чадварын нэмэгдэл олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.4, 67.5, Засгийн газрын 2018 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 382 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтын "Төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журам"-ыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Төрийн үйлчилгээний албан хаагчдын сарын ажлыг дүгнэж, зохих үнэлгээ авсан тул ур чадварын нэмэгдлийг хавсралт ёсоор олгосугай.

2.Ур чадварын нэмэгдлийг тэсвөөс гаргахыг Санхүү албаны нягтлан бодогч (Х.Ариунгуа)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА

В.ГАНТУЯА





ГОВЬСҮМБЭР АЙМАГ  
БАЯНТАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2022 оны 04 сарын 01 өдөр

Дугаар А/06

Баянтал сум

Байгууллагын хөдөлмөрийн дотоод  
журмыг шинэчлэн батлах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь заалт, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Хөдөлмөрийн тухай хуулийн 122 дугаар зүйлийн 122.1 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1.Засаг даргын Тамгын газрын “Хөдөлмөрийн дотоод журам”-ыг хавсралтаар шинэчлэн баталсугай.

2.Хөдөлмөрийн дотоод журмыг мөрдөж ажиллахыг нийт ажилтан, албан хаагчдад үүрэг болгосугай.

3.Энэ тушаал гарсантай холбогдуулан 2021 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн А/17 дугаар тушаалыг хүчингүй болгосонд тооцсугай.

ДАРГА

В.ГАНТУЯА



ГОВЬСҮМБЭР АЙМАГ  
БАЯНТАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2022 оны 04 сарын 12 өдөр

Дугаар 4/07

Баянтал сум

Ажлын хэсэг томилох тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.2, 20.1.10 дахь заалт, Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлын 2021 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн 37 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Баянтал сумын ЗДТГ-ын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй LEXUS 470 маркийн 00-03 ГСА улсын дугаартай автомашиныг дуудах дуулдага худалдааг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга :

М.Бодьгэрэл (Хууль эрх зүйн мэргэжилтэн)

Гишүүд:

Х.Ариунгуа (Санхүү албаны нягтлан бодогч)

Э.Буянтогтох (Төрийн сангийн мэргэжилтэн)

Н.Сарантуяа(Аж ахуйн нярав)

Х.Алтанцэцэг (Орон нутгийн өмчийн газрын өмчийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн)

2. Дуудлага худалдааг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу зохион байгуулж, орлогыг орон нутгийн орлогод төвлөрүүлж, үр дүнг танилцуулахыг ажлын хэсгийн дарга /М.Бодьгэрэл/-д даалгасугай.

3.Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Дотоод ажил хариуцсан мэргэжилтэн / Л.Отгонпүрэв/-т даалгасугай.



В.ГАНТУЯА